



## “МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 81 дүгээр зүйлийн 81.5.1, 81.5.2, “Монгол шуудан” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3.9, 8.18.1 дэх заалтыг тус тус үндэслэн **“Монгол шуудан” ХК-ийн гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтыг зарлаж байна.**

**Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчид тавигдах шаардлага, шалгуур:**

### **Боловсрол**

- Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбоо, тээвэр, логистик, олон улсын худалдаа, банк санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага, менежмент, хууль эрх зүйн чиглэлээр дээд боловсролтой;
- Магистр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Англи хэлний ярианы болон бичгийн ахисан түвшний мэдлэгтэй;

### **Ур чадвар**

- Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг оновчтой, шуурхай удирдан зохион байгуулах;
- Асуудлыг шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх, бодлого төлөвлөн боловсруулах;
- Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, логистик, санхүүгийн мэргэжлийн өндөр чадвартай;

### **Туршлага**

- Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбоо, тээвэр, логистик, олон улсын худалдаа, банк санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага, менежмент, хууль эрх зүйн салбарт удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан, компанийн үйл ажиллагааны менежментийг хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулсан туршлагатай байх;
- Бизнесийн салбарт ажиллаж байсан, төр, хувийн хэвшил, хувьцаа эзэмшигчид хоорондын уялдаа холбоог ханган ажиллаж байсан туршлагатай байх;
- Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбоо болон бусад томоохон төсөл хөтөлбөрүүд дээр ажиллаж байсан туршлагатай байх;
- Гадаадын бизнесийн болон олон улсын байгууллагууд, харилцагч, түншүүдтэй хамтран ажиллаж, бизнес хийж байсан туршлагатай байх;

### **Бусад шаардлага**

- Монгол улсын иргэн байх;
- Шүүхийн шийдвэрээр эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;
- Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;
- Тодорхой албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулах эрхээ шүүхийн шийдвэрээр хасуулаагүй байх;
- Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлээгүй байх;
- Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;
- Ёс зүй болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;
- Өөрөө, эсвэл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй байх;
- Шуудангийн тухай хуулийн 3.1.13-т заасан үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдэд хувьцаа эзэмшигч, нэгдмэл ашиг сонирхолтой этгээд сонгон шаргаруулалтад оролцохыг хориглоно;

*Жич: Компанийн засаглалын гэрчилгээтэй, нээлттэй хувьцаат компанийн удирдлагын түвшинд ажиллаж байсан, хөрш хоёр орны аль нэг улсын хэлээр ярианы болон бичгийн ахисан түвшний мэдлэгтэй бол давуу тал болно.*

### **Бүрдүүлэх материал:**

1. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл (өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлсэн байх);
2. “Монгол шуудан” ХК-ийн хөгжлийн мөрийн хөтөлбөр;
3. Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа /E-Mongolia/;
4. Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт /E-Mongolia/;

5. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /E-Mongolia/;
6. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт /E-Mongolia/;
7. Нэр дэвшигчийн дэлгэрэнгүй анкет (Төрийн албан хаагчийн анкетын загвар дээр);
8. Боловсролын диплом, үнэмлэхийн нотариатаар баталгаажсан хуулбар (гадаадад их, дээд сургууль төгссөн бол баталгаат орчуулгын хамт);
9. Иргэний үнэмлэхийн лавлагаа /E-Mongolia/;
10. Өмнө эсвэл одоо ажиллаж байгаа газраас гаргасан ажил байдлын тодорхойлолт;
11. Сүүлийн 5 жилийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа /E-Mongolia/;
12. 4х3 хэмжээтэй 2 хувь цээж зураг;

**Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хаяг:**

Улаанбаатар хот, Төв шуудангийн баруун хаалга, “Монгол шуудан” ХК-ийн байр, 208 тоот хаягаар (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Цэцгээ, Утас: 99120278) хүлээн авна.

**Материал хүлээн авах хугацаа:**

Сонгон шалгаруулалтад орох иргэний материалыг **2024** оны **03** сарын **11**-ны өдрийн **17:00** цаг хүртэл авна.

**Анхаарах зүйлс:**

- Хүлээлгэн өгч байгаа материал битүүмжлэгдсэн байх ба дугтуйны зүүн дээд буланд сонгон шалгаруулалтад орж буй иргэн өөрийн хаяг, утасны дугаарыг заавал бичсэн байна.
- Битүүмжлэгдсэн дугтуйны баруун доод буланд “Монгол шуудан” ХК, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороонд, Улаанбаатар 15160” гэсэн хаяг бичсэн байна.
- Битүүмжлэгдсэн дугтуйн дотор сонгон шалгаруулалтын баримт бичгийн жагсаалт болон нийт хуудасны тоог бичин гарын үсэг зурсан байна.
- Материалыг сонгон шалгаруулалтын дараа буцаан олгохгүй болно.
- Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахаас татгалзана.
- Материалын бүрдэл дутуу тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.
- Хүчин төгөлдөр бус баримт ирүүлсэн тохиолдолд баримт бичгийн бүрдэл дутуу гэж үзнэ.
- Эцсийн шатанд шалгарсан нэр дэвшигчидтэй Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооноос холбогдож ярилцлагын шалгалт авна.

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ  
ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

2024.02.26